

БАТЛАВ:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА



Б.САРУУЛ

**ХҮҮХДИЙН БАЯРЫГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
“МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ-МИНИЙ ИРЭЭДҮЙ”
СЭДЭВТ ГАР ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭНГИЙН УДИРДАМЖ**

Зохион байгуулагч: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын Урчуудын Эвлэлийн хороо, “Ирээдүйн Монгол” ТББ.

Зорилго: Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд багачуудын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдний дотоод ертөнц, хүсэл мөрөөдөл, санал санаачилгыг гар зургийн бүтээлээр дамжуулан шийдвэр гаргах түвшинд хүргэхэд оршино.

Хүрэх үр дүн:

1. Хүүхдүүд санал бодлоо илэрхийлэх аргад суралцана.
2. Хүүхдүүдийн дуу хоолой, санал бодлыг төр засаг, олон нийт сонсож, шийдвэр гаргахдаа анхаарч тусгадаг соёл, хандлага төлөвшихөд нөлөө үзүүлнэ.

Хугацаа: 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдөр хүртэл.

Хамрах хүрээ: Монгол Улсын хэмжээнд 6-18 хүртэлх насны хүүхдүүд.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Бүтээл нь “Монголын ирээдүй-Миний ирээдүй” сэдэвтэй уялдсан байх;
- Бүтээлийн агуулга хүүхдийн өөрийн хүсэл мөрөөдөл, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, боловсрол, чөлөөт цагийг өнгөрүүлэх орчин гэх мэт хүүхдийн чөлөөт сэтгэлгээ, арга ажиллагааг эрхэмлэн дотоод ертөнцийг нь нээж хүсэл мөрөөдөл, бодол санааг нь илүү гаргасан байх;
- Хүүхэд өөрийн сайн дурын үндсэн дээр бүтээл туурвих;
- Хүүхэд бүтээл туурвих үед утга санаа, агуулгад хэн нэгэн насанд хүрсэн хүн нөлөөлөхгүй байх (багш, эцэг эх, бусад);
- Бүтээлийг А-3 /42*29.7/ хэмжээтэй ватум цаас болон зургийн зориулалтын цаасан дээр усан будаг, тосон харандаа /пастель/, өнгийн харандаа, гуаш /шороон будаг/ зэрэг зориулалтын материалаар зурах;
- Үзэсгэлэнд нэг хүүхэд нэг л бүтээлээр оролцоно. Оролцож байгаа хүүхдүүд нь овог, нэр, нас, регистрийн дугаар, сургууль, анги, бүлэг, холбоо барих утас (эцэг, эх, анги удирдсан багш) зөв бичиж, 3x4 хэмжээтэй өнгөт цээж зургийн хамт бүтээлийн арын баруун доод хэсэгт нааж, зарласан хугацаанд зургийн хамт ирүүлэх;

- Бүтээл нугаларч, гэмтээгүй байх;
- Нийслэл болон орон нутгийн сургуулийн нийгмийн ажилтан хүүхэд бүрийн оролцоог дэмжин хамруулах;

Жич: “Монголын ирээдүй-Миний ирээдүй” гар зургийн үзэсгэлэнгийн албан ёсны цахим хуудас (www.futureofmongolia.mn) -аас цуврал зөвлөгөө, сургалтыг үзэх боломжтой.

Хүлээн авах:

- Орон нутгийн оролцогч хүүхдүүдийн бүтээлийг сургууль тус бүрийн нийгмийн ажилтан хүлээн авч дугтуйн дээр “Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Танаа” гэж хаяглан, тухайн аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлж нэгтгэн, 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө шуудангаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.
- Нийслэл хотоос оролцогч хүүхдүүдийн бүтээлийг сургууль тус бүрийн нийгмийн ажилтан хүлээн авч нэгтгэн, дугтуйн дээр “Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Танаа” гэж хаяглан, 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө шуудангаар нэгдсэн байдлаар ирүүлнэ.
- 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө шуудангаар илгээж амжаагүй бол Монгол Улсын Засгийн газрын 11-11 төв буюу Иргэд хүлээн авах байранд 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 17:00 цагаас өмнө өгч болно.

Жич: Заасан хугацаанаас хоцорч илгээсэн бүтээлийг хүлээж авахгүй болохыг анхаарна уу.

Шалгаруулалт:

- Бүтээлийг 6-9, 10-14, 15-18 насны ангиллаар 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн дотор мэргэжлийн комисс дүгнэнэ.
- Шалгарсан шилдэг 300 бүтээлээр 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 10:00 цагт Төрийн ордны Төрийн түүхийн музейн үзэсгэлэнгийн танхимд “МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ - МИНИЙ ИРЭЭДҮЙ” гар зургийн үзэсгэлэн гаргана.
- Шилдгээр шалгарсан эхний 100 бүтээлийн эздэд 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр холбогдох утсаар албан ёсоор мэдэгдэх бөгөөд Төрийн ордонд зохион байгуулагдах үзэсгэлэнд өөрийн хүсэлтээр асран хамгаалагчийн хамт биечлэн оролцож болно.

Холбоо барих утас: 51-262129, 70156994, 88001540, 80062907